

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/288/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/187
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 13 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019020430

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,533,633.86	163,207,861.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,811,822.64	100,065,415.59
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	79,811,822.64	100,065,415.59
31210	Төгрөг	79,811,822.64	100,065,415.59
31211	Төрийн сангийн харилцах	79,811,822.64	100,065,415.59
33	АВЛАГА	2,647,111.22	930,000.00
33500	Бусад авлага	2,647,111.22	930,000.00
33510	Байгууллагаас авах авлага	1,717,111.22	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	930,000.00	930,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	62,074,700.00	62,212,446.00
35400	Хангамжийн материал	62,074,700.00	62,212,446.00
35410	Бичиг хэргийн материал	1,646,573.00	1,028,499.00
35420	Аж ахуйн материал	58,393,142.00	54,300,142.00
35440	Түлш, шатах тослох материал	118,400.00	0.00
35460	Хүнсний материал	1,826,485.00	6,793,705.00
35470	Бусад хангамжийн материал	90,100.00	90,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,371,959,263.51	2,339,982,555.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,371,959,263.51	2,339,982,555.12
39200	Биет хөрөнгө	2,360,481,263.51	2,328,184,555.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,301,287,207.74	2,301,287,207.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162,622,655.72	-216,680,518.57
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	81,276,204.00	109,788,704.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,489,116.63	-50,743,747.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,370,541.89	149,168,541.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,484,155.31	-70,230,996.46
39209	Зам, гүүрийн байгууламж	42,912.00	42,912.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,776,073.00	163,121,073.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-60,160,653.27	-68,053,526.64
39217	Ном	10,484,905.81	10,484,905.81
39300	Биет бус хөрөнгө	11,478,000.00	11,798,000.00
39301	Програм хангамж	536,500.00	856,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-536,500.00	-536,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,516,492,897.37	2,503,190,416.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,419,725.00	8,599,746.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,419,725.00	8,599,746.36
41300	Өглөг	4,419,725.00	8,599,746.36
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	425,000.00	4,724,746.36
41360	Бусад өглөг	3,994,725.00	3,875,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,994,725.00	3,875,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,512,073,172.37	2,494,590,670.35
51	Засгийн газрын хувь оролцоо	2,512,073,172.37	2,494,590,670.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	675,096,458.81	675,096,458.81
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	675,096,458.81	675,096,458.81
51200	Хуримтлагдсан үр дүн	1,156,098,715.14	1,138,616,213.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,370,021,233.13	1,156,098,715.14
51220	Тайлант үеийн үр дүн	2,526,119,948.27	-17,482,502.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	680,877,998.42	680,877,998.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,516,492,897.37	2,503,190,416.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,415,497,116.32	1,095,539,448.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,481,564,498.33	39,940,748.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,481,564,498.33	39,940,748.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,503,800.00	1,503,800.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,503,800.00	1,503,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,433,906,243.33	38,286,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	46,154,455.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	933,932,617.99	1,055,598,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,349,400.00	822,323,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,349,400.00	822,323,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,504,900.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,504,900.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	213,078,317.99	233,275,400.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	213,078,317.99	233,275,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	889,377,168.05	1,113,021,950.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	889,377,168.05	1,113,021,950.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,880,253.05	1,108,394,900.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,252,037.08	578,764,104.95
210101	Үндсэн цалин	335,373,388.17	433,587,856.08
210102	Нэмэгдэл	72,158,038.64	116,293,741.28
210104	Урамшуулал	22,720,610.27	28,882,507.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,894,705.15	78,226,301.32
210201	Тэтгэврийн даатгал	26,560,223.69	48,432,970.53
210202	Тэтгэмжийн даатгал	4,346,497.15	12,079,896.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,477,197.55	4,672,108.80
210204	Ажилгүйдлийн даатгал	862,003.88	1,140,545.19
210205	Эрүүл мэндийн даатгал	53,648,782.88	11,900,780.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,723,326.00	215,405,146.36
210301	Гэрэл, цахилгаан	2,339,445.00	8,822,186.36
210302	Түлш, халаалт	171,143,881.00	206,552,960.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	537,600.00	5,222,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	94,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,304,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	537,600.00	1,823,400.00
2105	Нормативт зардал	72,006,805.00	91,073,290.00
210502	Хоол, хүнс	72,006,805.00	91,073,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	29,116,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	29,116,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,880,000.00	3,245,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,880,000.00	3,245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,585,779.82	107,343,057.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,041,200.00	18,716,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,492,100.00	4,674,249.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,052,479.82	83,952,208.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,496,915.00	4,627,050.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,496,915.00	4,627,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,542,015.00	4,627,050.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,526,119,948.27	-17,482,502.02
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,526,119,948.27	-17,482,502.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	935,436,417.99	1,057,253,148.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,503,800.00	1,654,448.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,503,800.00	1,654,448.00
12000	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,503,800.00	1,503,800.00
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,503,800.00	1,503,800.00
1200041	Бусад орлого	0.00	150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	933,932,617.99	1,055,598,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,349,400.00	822,323,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,349,400.00	822,323,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,504,900.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,504,900.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	213,078,317.99	233,275,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	213,078,317.99	233,275,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	834,519,095.35	1,023,310,355.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,519,095.35	1,023,310,355.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	795,531,630.35	990,583,655.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,417,204.35	574,949,695.05
210101	Үндсэн цалин	346,444,262.52	413,358,879.68
210102	Нэмэгдэл	93,750,043.35	130,660,661.99
210104	Урамшуулал	15,222,898.48	30,930,153.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,976,700.00	80,323,600.00
210201	Тэтгэврийн даатгал	44,864,100.00	54,650,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,278,200.00	6,429,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,222,600.00	5,144,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,057,306.63	1,285,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,554,493.37	12,813,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,723,326.00	213,275,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,339,445.00	10,792,186.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	675,096,458.81	680,877,998.42	-1,370,021,233.13	-14,046,775.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	-1,370,021,233.13	-14,046,775.90
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,526,119,948.27	2,526,119,948.27
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,156,098,715.14	2,512,073,172.37
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,156,098,715.14	2,512,073,172.37
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,156,098,715.14	2,512,073,172.37
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,482,502.02	-17,482,502.02
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,138,616,213.12	2,494,590,670.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	904,217,400.00	803,724,155.05	100,493,244.95	88.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	904,217,400.00	803,724,155.05	100,493,244.95	88.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	867,803,900.00	770,997,455.05	96,806,444.95	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,232,000.00	574,949,695.05	89,282,304.95	86.6
210101	Үндсэн цалин	469,306,900.00	413,358,879.68	55,948,020.32	88.1
210102	Нэмэгдэл	169,450,000.00	130,660,661.99	38,789,338.01	77.1
210104	Урамшуулал	25,475,100.00	30,930,153.38	-5,455,053.38	121.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,029,300.00	80,323,600.00	2,705,700.00	96.7
210201	Тэтгэврийн даатгал	56,460,100.00	54,650,200.00	1,809,900.00	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,642,300.00	6,429,900.00	212,400.00	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,313,800.00	5,144,100.00	169,700.00	96.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,328,500.00	1,285,700.00	42,800.00	96.8
210205	Эрүүл мэндийн даатгал	13,284,600.00	12,813,700.00	470,900.00	96.5
2105	Нормативт зардал	71,418,600.00	67,940,860.00	3,477,740.00	95.1

21050 2	Хоол, хүнс	71,418,600.00	67,940,860.00	3,477,740.00	95.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,393,600.00	5,318,800.00	1,074,800.00	83.2
21080 1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,931,600.00	1,503,800.00	427,800.00	77.9
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,462,000.00	3,815,000.00	647,000.00	85.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,730,400.00	42,464,500.00	265,900.00	99.4
21090 1	Бараа үйлчилгээний бусад зардал	36,037,400.00	35,772,200.00	265,200.00	99.3
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,693,000.00	6,692,300.00	700.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,413,500.00	32,726,700.00	3,686,800.00	89.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,413,500.00	32,726,700.00	3,686,800.00	89.9
21320 5	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,413,500.00	32,726,700.00	3,686,800.00	89.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	904,217,400.00	823,827,100.00	80,390,300.00	91.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	822,323,300.00	822,323,300.00	0.00	100.0
31000 1	Улсын төсвөөс санхүүжих	822,323,300.00	822,323,300.00	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	81,894,100.00	1,503,800.00	80,390,300.00	1.8
35000 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,931,600.00	1,503,800.00	427,800.00	77.9
35000 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,700.00	0.00	150,700.00	0.0
35000 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	79,811,800.00	0.00	79,811,800.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	79,811,822.64	-79,811,822.64	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	100,065,415.59	-100,065,415.59	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 88,9 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус сургууль нь 36 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард Төв аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтанд 92,5 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт *ороогүй* байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,302.4 мянган төгрөгөөр буюу 0.53 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	79,811.8	100,065.4	20,253.5
Авлага	2,647.1	930.0	-1,717.1
Урьдчилгаа			
Бараа материал	62,074.7	62,212.4	137.75
Үндсэн хөрөнгө	2,371,959.2	2,339,982.5	-31,976.71
Нийт хөрөнгө	2,516,492.8	2,503,190.4	-13,302.4
Өр төлбөр	4,419.7	8,599.7	4,180.02
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,512,073.1	2,494,590.7	-17,482.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,516,492.8	2,503,190.4	-13,302.4

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 100,065.4 мянган төгрөг өмнөх оноос 20,253.6 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны төсвийн гүйцэтгэл орон тоо дутуу цалин, нэмэгдэл хэмнэсэнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 930.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1,717.1 мянган төгрөгөөр буурсан нь авлагыг барагдуулж ажиллсантай холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 137.7 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой.

Үндсэн хөрөнгө данс 31,976.7 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 8,599.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 4,180.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд байгууллагад өгөх 4,300.0 мянган төгрөг, 4,299.7 мянган төгрөгийн халаалтын үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 670,342.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 233,875.4 мянган төгрөг, нийт 904,217.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 904,217.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 904,217.4 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 904,217.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 568,344.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 233,275.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 1,503.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 803,724.1 төгрөг буюу 88.9 хувьтай байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 803,724.1 мянган төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 100,493.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 3,477.7 мянган төгрөгөөр, тэтгэвийн болон бусад даатгалын зардал 2,705.7 мянган төгрөгөөр, хүүхдийн үдийн цай хөтөлбөрийн зардал 3,686.8 мянган төгрөгөөр, үндсэн цалингийн зардал 55,948.0 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардал 38,789.3 мянган төгрөгөөр, мэдээллийн үйлчилгээний зардал 647.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,784.8	1,784.8		100%
2	80312 Сургалт семинар	892.4	886.2	6.200.0	99.3%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,784.8	1,784.8		100%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	36,413.5	32,726.7	3,686.8	89.88%
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	111,288.2	93,121.4	18,166.7	8.67%
6	81816 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	18,301.7	18,301.7		100%
7	81823 Мэргэжил дээшлүүлэх	4,015.8	3,908.2	107.6	97.3%
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	6,440.0	4,366.9	2,073.1	67.8%
9	81834 Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	558,059.2	524,903.0	33,156.1	94.05%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	163,154.7	120,436.5	42,718.1	73.8%
11	81844 Төрөлжсөн сургалт	150.7			
12	81848 түрээсийг сурах бичиг	1,931.6	1,503.8	427.8	77.8%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	233,875.4	233,875.4		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-80111	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 100%	233,875.4	233,875.4
2	71801-80226	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Байр ашиглалтын үйлчилгээ 100%	1,784.8	1,784.8
3	71801-80312	2023-12-31	Сургалтын чанар сайжруулах	Сургалт семинар 99.3%	892.4	886.2
4	71801-81605	2023-12-31	Урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийг дэмжих 100%	1,784.8	1,784.8
5	71801-81801	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Үдийн цай хөтөлбөр 89.9%	36,413.5	32,726.7
6	71801-81806	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Дотуур байрны үйлчилгээ 83.67%	111,288.2	93,121.4
7	71801-81816	2023-12-31	Хүүхэд бүрийг компьютертэй болгох	Хүүхдэд ээлтэй орчин 100%	18,301.7	18,301.7
8	71801-81823	2023-12-31	Мэргэшүүлэх	Мэргэжил дээшлүүлэх 97.3%	4,01.8	3,908.2
9	71801-81827	2023-12-31	Иргэн бүрийг бичиг үсэгтэй болгох	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр 67.8%	6,440.0	4,366.9
10	71801-81834	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 94.05%	558,059.2	524,903.0
11	71801-81835	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 73.8%	163,154.7	120,436.5
12	71801-81844	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрөлжсөн сургалт 0%	150.7	
13	71801-81848	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Түрээсийн сурах бичиг 77.8%	1,931.6	1,503.8

Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны үйлчилгээ арга хэмжээнүүд нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Бичиг үсгийн боловсрол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хамрагдах хүүхдийн тоо муу ирц хангалтгүйгээс дутуу хэрэгжсэн байна.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Тендер зарласан боловч оролцох байгуулага байхгүйн улмаас Гурван булаг ХХК-тай гэрээ байгуулан шууд худалдан авалтаар худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлвөлгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог, нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь, Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,000,000.0 мянган төгрөгнөөс 2.0 хувиар буюу 20,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,000.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 13 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан

ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 89,282.3 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 2,705.7 мянган төгрөгөөр
- Нормативт зардал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 4,552.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 152 мэдээллийг байршуулж 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хувь хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	163,852.0	4	163,852.0	100%
Зөвлөмж	2	55,252.5	2	55,252.5	100%
Нийт дүн	1	219,104.5	1	219,104.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдсангүй.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,230.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 4,300.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 930.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагад өгөх өглөгийг харилцан тооцоо нийлж баталгаажуулаагүй 4,300.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг дагаж мөрдөөгүй “Эрх ба үүрэг” мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гэрээт ажлын хугацаа дуусаагүй авлагын үлдэгдэл 930.0 мянган төгрөг байна. Энэ нь НББ-н тухай хуулийн 20.2.5 “Дансны өглөг,авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид өглөг, авлагыг цаг тухайд барагдуулах, үлдэгдэлтэй бол дансны авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулж ажиллахыг зөвлөв.

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлагын тооцоо нийлж баталгаажуулах	1	930.0					1	930.0				
Байгууллагд өгөх өглөгийг харилцан тооцоо нийлж үлдэгдлээ баталгаажуулаагүй	1	4,300.0	1	4,300.0								
Дүн	1	5,230.0	1	4,300.0			1	930.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
159 мэдээлэл оруулахаас 152 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 7 мэдээлэл хоцроож байршуулсан байна.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn